



## АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 8/21

Улаанбаатар хот

### Ц.Шийлэгбатад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 48.1, 48.1.2, 48.3, Захиргааны ерөнхий хуулийн 26.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Архивын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 13.1, 13.3 дахь хэсэг, Цэрэннадмидын Шийлэгбаттай 2019 оны 02 сарын 27, 03 сарын 01-ний өдөр хийсэн сонсох ажиллагааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Шийлэгбат нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.9, 37.1.16, Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.4, 6.2.7, 6.3.2, 6.3.4, 6.3.5-д заасныг зөрчиж байгууллагын баримт бичгийг удирдлагын зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулсан, ажлын цагаар ажлын байраа орхиж явсан, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлийг гаргасан болох нь байгууллагын дотоод хяналт, шалгалтаар тогтоогдсон тул Ц.Шийлэгбатад албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөж, үүрэг ажилдаа хариуцлагатай хандахыг Ц.Шийлэгбатад үүрэг болгосугай.

3. Дээрх зөрчлийг гаргахгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

4. Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо энэхүү шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Төрийн албаны зөвлөлд эсхүл шүүхэд гаргаж болохыг дурдсугай.

ДАРГА



С.ЭНХБААТАР

368110175  
Tushaal